



МОНГОЛЫН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГА

МОНГОЛЫН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН-2017



Улаанбаатар хот
2018 он

ӨМНӨХ ҮГ



Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлага (ОУИТБС) гэдэг нь байгалийн баялгаас (ашигт малтмал, газрын тос, байгалийн хий) олж буй орлогыг олон нийтэд ил тод болгосноор түүнийг нийтийн сайн сайхны төлөө зөв захиран зарцуулахад нь оролцогч талуудын хариуцлагыг өндөржүүлэх, сайн засаглалыг бэхжүүлэхэд чиглэсэн төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн тэгш оролцоо бүхий дэлхий нийтийн түншлэл юм.

ОУИТБС нь нэг талаас олборлох үйлдвэрлэл эрхлэгч компаниуд төлснөө тайлагнана, нөгөө талаас Засгийн газар тэдгээр компаниудаас хүлээн авсан орлогоо тайлагнана. Хоёр талаас ирүүлсэн тайланг олон улсын хөндлөнгийн аудитын байгууллага хянан нэгтгэж, нэгдсэн тайлан гаргаж, түүнийг олон нийтэд ил тод болгодог. Энэхүү үйл

явцыг төр, компани, иргэний нийгмийн тэгш оролцоо бүхий олон талт оролцогчдын бүлэг удирдан явуулж, хянан зохицуулдаг.

Тиймээс оролцогч талуудад олборлох үйлдвэрлэлийн талаар мэдлэг, мэдээллийг тогтмол өгч байгалийн баялгаас олж буй орлогыг нийтийн сайн сайхны төлөө зөв захиран зарцуулах үйл явцад сонирхогч талуудын хяналт, оролцоог нэмэгдүүлэх, ил тод байдлыг сайжруулах зорилгоор “Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын хураангуй тайлан-2017” товхимлыг анх удаа боловсруулан толилуулж байна.

Энэхүү товхимол нь үндсэн зургаан хэсгээс бүрдэх бөгөөд байгалийн баялгаас олж буй орлого, олборлох салбараас эдийн засаг, нийгэмд оруулсан хувь нэмэр, эрх зүйн зохицуулалт, ашиг хүртэгчдийн талаарх үндсэн ойлголтыг ОУИТБС-ын 2017 оны нэгтгэлийн мэдээллээр жишээ болгон “инфографик” буюу “зурган мэдээлэл” хэлбэрээр энгийн ойлгомжтой байдлаар хүргэхийг зорьсон.

Товхимлыг хэвлэмэл байдлаар авч болохоос гадна цахим хэлбэрээр ОУИТБС-ын Ажлын албаны www.eitimongolia.mn хуудаснаас үзэж болно.

Энэ дашрамд, товхимлын агуулгыг боловсруулж, санхүүжүүлэн хамтран ажилласан ОУИТБС-ын Ажлын алба, Харт Нойрс, Улаанбаатар аудит корпораци ХХК-ийн ажилтнууд, зураг, дизайныг бэлтгэсэн “Шинжилгээ, загварчлал, шийдэл” ТББ-д гүн талархал илэрхийлж байна.

**Улаанбаатар Аудит Корпораци ХХК-ийн
Ерөнхий захирал Б.Осоргарав**

“Харт Нойрс” Лтд
Мэргэшсэн Нягтлан бодогчид
89 High Street Thame, Oxfordshire
3EH England

Утас: 44 01844 21 88 36
Вебсайт: www.hart-nurse.co.uk

“Улаанбаатар Аудит Корпораци” ХХК
Далай тауэр, 9 дүгээр давхар
Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо
Юнеско гудамж, Улаанбаатар хот
Монгол Улс
Утас: 976-7011-0744, 976-7011-0799
Вебсайт: www.grantthornton.mn

**Монголын Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод
Байдлын Санаачилгын Ажлын Хэсэг**

Монгол Улсын ОУИТБС-ын Засаглалыг дэмжих төсөл
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Амарын гудамж, Туушин компанийн байр 314 тоот

2018 оны 12 сарын 19-ний өдөр

Англи Улсын “Харт Нойрс” Лтд ба Монгол Улсын “Улаанбаатар Аудит Корпораци” ХХК-ийн консорциум нь МОУИТБС-ын 12 дугаар тайлан буюу 2017 оны Нэгтгэлийн ажлыг (“Гэрээт ажил”) хийхээр сонгогдон, гэрээ байгуулсан.

Монголын эрдэс баялгийн салбарт уул уурхайн болон газрын тосны үйлдвэрлэл, хайгуулын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдээс 2017 онд Засгийн газарт төлсөн материаллаг төлбөр хийгээд Засгийн газрын хүлээн авсан материаллаг орлогын урсгалын аудитын нэгтгэлийн гэрээт ажлыг 2018 оны 07 дугаар сарын 19-ний өдрөөс 2018 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

Бид энэхүү хураангуй тайланг МОУИТБС-ын 2017 оны тайланд үндэслэн бэлтгэсэн ба дэлгэрэнгүй мэдээллийг МОУИТБС-ын цахим хуудас (www.eitimongolia.mn)-д байршуулсан үндсэн тайлан болон түүний хавсралтуудаас үзэж болно.

Монголын ОУИТБС-ын Ажлын хэсгээс баталсан Гүйцэтгэх ажлын даалгаварт тусгагдсан ажлуудыг Холбогдох үйлчилгээний олон улсын стандарт 4400 буюу Санхүүгийн мэдээлэлд тохиролцсон горимуудыг гүйцэтгэх гэрээт ажлын стандартын дагуу хийж гүйцэтгэсэн. Бидний гүйцэтгэсэн горимууд нь нэгтгэлийн болон шалгах ажлыг АОУС буюу Шалгах Ажлын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэх зорилго агуулаагүй бөгөөд бидний зүгээс энэхүү тайланд харуулсан тодорхой мэдээллүүд, тэдгээртэй холбогдох аливаа гүйлгээнүүдэд ямар нэгэн баталгаа өгөх үүрэггүй юм.

Тус тайлан нь зөвхөн заагдсан зүйлсийн хүрээнд хийгдсэн бөгөөд аливаа нэгэн нэгжийг бүхлээр нь хамарсан санхүүгийн тайлангуудийн хүрээнд хийгдээгүй.

“Харт Нойрс” Лтд
Мэргэшсэн Нягтлан бодогчид

“Улаанбаатар Аудит Корпораци” ХХК

ТОВЧЛОЛ

ААН	Аж ахуйн нэгж	Entity
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	Corporate Income Tax
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар	Mineral Resources and Petroleum Authority
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	Fee for exploitation and exploration of mineral resources
АНУ	Америкийн нэгдсэн улс	The United States of America
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт	International Standards on Auditing
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос улс	The Republic of Korea
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард улс	The People's Republic of China
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам	Ministry of Environment and Tourism
БХГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээ	Product Sharing Agreement
ГЕГ	Гаалийн ерөнхий газар	Customs General Administration
ДНБ	Дотоодын нийт бүтээгдхүүн	Gross Domestic Product
ЗГ	Засгийн газар	Government
МОУИТБС	Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга	Mongolia Extractive Industry Transparency Initiative
МУ	Монгол Улс	Mongolia
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар	State Professional Inspection Agency
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага	United nations
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар	Value Added Tax
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуйн нэгж	Local-Owned entities
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан	General Local Development Fund
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан	Local Development Fund
ОТАХ	Олон талт ажлын хэсэг	Multi-Stakeholder Working Group
ОУИТБС	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга	Extractive Industry Transparency Initiative
СЯ	Сангийн яам	Ministry of Finance
ТББ	Төрийн бус байгууллага	Non-governmental Organization
ТЕГ	Татварын ерөнхий газар	General Department of Taxation
ТӨААН	Төрийн өмчит аж ахуйн нэгж	State-Owned Entities
ТӨК	Төрийн өмчит компани	State-Owned Companies
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл	Technical and Economic Feasibility Study
УИХ	Улсын их хурал	Parliament of Mongolia
УУХҮЯ	Уул уурхайн хүнд үйлдвэрлэлийн яам	Ministry of Mining and Heavy Industry
ҮАГ	Үндэсний аудитын газар	Mongolian National Audit office
ХБ	Хөрөнгийн бирж	Stock Exchange
ХБХН	Хараат бус хянагч-нэгтгэгч	Independent Administrator
ХК	Хувьцаат компани	Joint Stock Company
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	Ministry of Labor and Social Protection
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	Limited Liability Company
ЭБМЗ	Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл	Mineral Professional Council




БҮЛЭГ 1. ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГА

ОУИТБС-ын тухай	7
Монгол дахь ОУИТБС-ын бүтэц	8
Он цагийн хэлхээс	9
МОУИТБС-ын тайлан нэгтгэлийн хураангуй	10



БҮЛЭГ 2. 2017 ОНЫ ТАЙЛАН НЭГТГЭЛИЙН АРГАЧЛАЛ

Нэгтгэл тайлангийн үйл явц	11
Нэгтгэлд оруулсан компаниудыг сонгох аргачлал	12
Мэдээллийн найдвартай байдал	12
Мэдээлэл цуглуулалт	13



БҮЛЭГ 3. НЭГТГЭЛИЙН ҮР ДҮН

Хураангуй	14
Нэгтгэлийн үр дүн - Засгийн газрын орлогын урсгалаар	15



БҮЛЭГ 4. ОЛБОРЛОХ САЛБАР

Салбарын тойм	17
Монгол Улсын эдийн засагт оруулсан хувь нэмэр	18
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	19
Ашигт малтмалын үйлдвэрлэл, экспорт	20
Ашигт малтмалын хайгуул, ашиглалт	21
Тусгай зөвшөөрөл олгох үйл явц	22
Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт	23
Тусгай зөвшөөрөл, хандив, орон нутгийн санхүүжилт	24
Тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудын тоо баримт	26
Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчид	27
Газрын тос ба байгалийн хий	28
Газрын тосны олборлолт, экспорт	29
Газрын тосны хайгуул	30
Ураны тухай	30
Засгийн газрын байгууллагууд	31
Эрх зүйн хүрээ ба төрөөс баримтлах бодлогууд	32
Олборлох салбар дахь төрийн оролцоо	34
Төрийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн мэдээлэл	35
Засгийн газар болон ТӨААН-үүдийн санхүүгийн харилцаа	36
Төсвийн үйл явц болон орлого хуваарилалт	37



БҮЛЭГ 5. БУСАД АСУУДЛУУД

Гэрээний ил тод байдал	39
Бенефициар өмчлөгч	40
Дэд бүтцэд хөрөнгө оруулах ба бартерын солилцоо	41
Тээврийн орлого	41
Цахим тайлагналын систем	42
Олборлох салбарын үзүүлж буй нийгмийн дэмжлэг	43
Нөхөн сэргээлт	44
Ашигласан усны мэдээлэл	46
Хог хаягдлын мэдээлэл	47



БҮЛЭГ 6. ЗӨВЛӨМЖ

48



МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ


Ашигт малтмал, газрын тосны газар	www.mrpam.gov.mn
Байгаль орчин, аялал жуучлалын яам	www.mne.mn
Гаалийн ерөнхий газар	www.customs.gov.mn
Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга	www.eitimongolia.mn
Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга	www.eiti.org
Орон нутгийн хөгжлийн сан	www.tusuv-oronnutag.mof.gov.mn
Сангийн яам	www.mof.gov.mn
Татварын Ерөнхий Газар	www.mta.mn
Тогтвортой бичил уурхай төсөл	www.sam.mn
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	www.pcsp.gov.mn
Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам	www.mmhi.gov.mn
Үндэсний аудитын газар	www.audit.mn
Статистикийн мэдээллийн нэгдсэн сан	www.1212.mn
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам	www.mlsp.gov.mn
Цөмийн энергийн комисс	www.nea.gov.mn
Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн сан	www.iltodgereee.mn

БҮЛЭГ 1. ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГА

ОУИТБС-ЫН ТУХАЙ

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга нь байгалийн баялаг (ашигт малтмал, газрын тос, байгалийн хий)-ийг олон нийтэд ил тод, хариуцлагатай байдлаар

удирдахад чиглэсэн төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн тэгш оролцоо бүхий дэлхий нийтийн түншлэл бөгөөд олон улсын хэм хэмжээ юм.



МОУИТБС-ын хэрэгжилт

Монгол Улсын хувьд ОУИТБС-ын стандартад заасан үндсэн 7 шаардлага, олон талт ажлын хэсгийн санаачлагаар нэмэлтээр ил тод

болгосон мэдээллийг багцалж дараах зурагт харуулав.

Гэрээ байгуулах, тусгай зөвшөөрөл олгох, институцийн хамрах хүрээ	Үйлдвэрлэлийн мэдээ	Төлбөр, орлого	Төрийн өмчийн компаниуд	Орлогын хуваарилалт	ОТАХ-ийн шаардлага
Эрх зүйн хүрээ болон төсвийн бодлого (2.1)	Хайгуулын үйл ажиллагаа (3.1)	Татвар болон үндсэн орлогууд (4.1)	ТӨК-ийн төрийн эзэмшлийн түвшин (2.6)	Орлогын хуваарилалт (5.1)	Хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн мэдээлэл
Тусгай зөвшөөрлийн олголт, бүртгэл (2.2, 2.3)	Үйлдвэрлэлийн тоо хэмжээ, үнэ өртөг (3.2)	Дэд бүтэц, бартерын гэрээ (4.3)	ТӨК-аас ЗГ-т шилжүүлсэн орлогууд (4.5)	Орон нутаг дахь шилжүүлэг (5.2)	Нөхөн сэргээлтийн мэдээ
Гэрээ, түүний ил тод байдал (2.4)	Экспортын тоо хэмжээ, үнэ өртөг (3.3)	Тээвэрлэлтийн орлого (4.4)	ТӨК-ийн төсвийн шинжтэй зардал (4.2)	Орлогын менежмент ба зарцуулалт (5.3)	Ашигласан усны мэдээлэл
Бенефициар өмчлөгч (2.5)	Эдийн засагт оруулсан хувь нэмэр (6.3)			Нийгмийн хөрөнгө оруулалт, зарцуулалт (6.1)	Хог хаягдлын мэдээ
					Ногдол ашгийн мэдээлэл
					Ажил олголт
					Мөнгөн ба мөнгөн бус хандив, дэмжлэг

МОУИТБС-ЫН БҮТЭЦ

Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (МОУИТБС) нь төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн тэгш оролцоог хангасан бүтэцтэй.


ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ (30 хүн)

МОУИТБС-ыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах



АЖЛЫН ХЭСЭГ (33 хүн)

МОУИТБС-ыг хэрэгжүүлэх



АЖЛЫН АЛБА (Орон тооны 5 хүн)

МОУИТБС-ын үндсэн зарчмуудыг хэрэгжүүлэхэд Үндэсний зөвлөл болон Ажлын хэсэгт туслах, шийдвэрийг хэрэгжүүлэх



ДЭД ЗӨВЛӨЛ / ДЭД АЖЛЫН ХЭСГҮҮД

Засгийн газрын 2012 оны 222-р тогтоолоор бүх шатны Засаг дарга нар нь аймаг, суманд 3 талын тэнцүү оролцоотой МОУИТБС-ын дэд зөвлөл байгуулах, үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэгтэй. Одоогоор нийслэл, 21 аймаг, 1 дүүрэг, 14 суманд дэд зөвлөл, 4 суманд жишиг зөвлөл байгуулагдаад ажиллаж байна.

ОН ЦАГИЙН ХЭЛХЭЭС

ОУИТБС нь Монгол Улсад 12 дахь жилдээ амжилттай хэрэгжиж, тэргүүлэгч орны нэг боллоо.

-
- Перугийн бага хурлаас ОУИТБС-ын даргын нэрэмжит шагналыг 2 дахь удаагаа хүртэв.
 - Сиднейн Бага хурлаас “ОУИТБС-ын стандарт” батлагдав.
 - Олон улсын Удирдах хорооны даргын нэрэмжит шагналыг Монгол Улс хүртэв.
 - Монгол улс Цахим тайлангийн системийг нэвтрүүлэв.
 - Парисын Бага хурлаас ОУИТБС-ын даргын нэрэмжит шагналыг Монгол Улс хүртэв.
 - Олон улсын баталгаажуулалт хийв.
 - МОУИТБС-ын ажлын албыг байгуулав.
 - “Нэр дэвшигч” орны статустай болов.
 - Засгийн газрын 80 дугаар тогтоолоор МОУИТБС-ыг хэрэгжүүлэх төрийн байгууллагуудын чиг үүргийг тогтоов.
 - Төр, компани, иргэний нийгмийн төлөөллүүд МОУИТБС-ыг хэрэгжүүлэх санамж бичигт гарын үсэг зурав.
 - Монгол Улс ОУИТБС-ын стандартын шаардлагыг хангасан дэлхийн 2-дох орон болов.
 - “Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай” хуулийн төслийг УИХ-д өргөн барив.
 - Монгол Улс ОУИТБС-ын “Шаардлагыг бүрэн хангасан” дэлхийн 4-дөх орон болов.
 - МОУИТБС-ын хэрэгжилтийг сайжруулах Засгийн газрын 2012 оны 222-р тогтоол батлагдав.
 - МОУИТБС-ыг хэрэгжүүлэх 2010-2014 оны дунд хугацааны стратегийг батлав.
 - Монгол Улсын ОУИТБС-ын анхдугаар нэгтгэл тайлан хэвлэгдэн гарав.
 - Монгол Улсын Засгийн газар ОУИТБС-ыг хэрэгжүүлэхээ тунхаглав.
 - Ашигт малтмалын тухай хуульд (48.10) нэмэлт заалт оруулав.



НҮБ-ын “Дэлхийн тогтвортой хөгжлийн дээд хэмжээний уулзалт”- аас гарсан санаачилгаар ОУИТБС хэрэгжиж эхлэв.

МОУИТБС-ЫН ТАЙЛАН НЭГТГЭЛИЙН ХУРААНГУЙ

ОУИТБС-д нэгдсэнээс хойш Монгол Улс 12 дахь удаагийн тайланг бэлтгэн гаргаад байна.

			Нэгтгэгдсэн дүн*	Тайлбар-лагдаагүй зөрүү	Материаллаг төлбөрийн босго
2017	30%	2091	2,207 тэрбум	48 сая	Улсын төсөв: 300 сая < Орон нутгийн төсөв: 100 сая <
Харт Нойрс, Улаанбаатар Аудит Корпораци ХХК		1489			
		230			
2016	19%	2086	1,086 тэрбум	74 сая	Улсын төсөв: 500 сая < Орон нутгийн төсөв: 150 сая <
Кэй Пи Эм Жи Франц, Монгол хамтарсан консорциум		1227			
		213			
2015	30%	1920	1,393 тэрбум	112 сая	Улсын төсөв: 250 сая < Орон нутгийн төсөв: 100 сая <
Харт Нойрс, Улаанбаатар Аудит Корпораци ХХК		747			
		202			
2014	25%	1570	1,579 тэрбум	581 сая	40 сая <
Кэй Пи Эм Жи Франц, Монгол хамтарсан консорциум		992			
		236			
2013	27%	1617	1,576 тэрбум	37 сая	40 сая <
Харт Нойрс, Улаанбаатар Аудит Корпораци ХХК		1197			
		250			
2012	33%	1829	1,594 тэрбум	360 сая	40 сая <
Мүүр Степенс ХХК, Далайван Аудит ХХК		1531			
		200			
2011	54%	518	2,150 тэрбум	75 сая	40 сая <
Харт Нойрс, Улаанбаатар Аудит Корпораци ХХК		301			
		200			
2010	48%	417	1,275 тэрбум	356 сая	50 сая <
Харт Нойрс, Улаанбаатар Аудит Корпораци ХХК		274			
		150			
2009	37%	363	737 тэрбум	58 сая	50 сая <
Харт Нойрс, Улаанбаатар Аудит Корпораци ХХК		129			
		101			
2008	32%	184	686 тэрбум	420 сая	100 сая <
Харт Нойрс, Улаанбаатар Аудит Корпораци ХХК		115			
		46			
2007	40%	184	745 тэрбум	775 сая	200 сая <
Монгол, Малайзын Эрнст Янг хамтарсан консорциум		102			
		38			
2006	36%	137	492 тэрбум	4,000 сая	200 сая <
Австралийн Крейн Уайт энд Ассоушиэтс		64			
		25			

■ Засгийн газрын тайланд орсон компаниуд
 ■ Нэгтгэлд хамрагдсан компаниуд
 ■ Ил тодын тайлан гаргасан компани
 ■ Хараат бус Хянагч-Нэгтгэгч

..% Улсын төсвийн урсгал орлогод эзлэх хувь


* Нэгтгэлд хамрагдсан компанийн тохируулгын дараах дүн

БҮЛЭГ 2. 2017 ОНЫ ТАЙЛАН НЭГТГЭЛИЙН АРГАЧЛАЛ

НЭГТГЭЛ ТАЙЛАНГИЙН ҮЙЛ ЯВЦ


МОҮИТБС-ын Ажлын алба нь олон улсын хөндлөнгийн аудитын байгууллагын тулган баталгаажуулалт хийж, аудитаар

баталгаажсан нэгдсэн тайланг олон нийтэд ил тод болгодог.



Тайлан мэдээллийг нэгтгэхэд Олборлох үйлдвэрлэлийн компаниудаас орлого хүлээн авсан, салбарыг хянах, зохицуулах, тайлан гаргуулах хариуцлага бүхий төрийн болон

орон нутгийн түвшний төрийн 42 байгууллага, олборлох салбарт ажиллаж байгаа төрийн, орон нутгийн болон хувийн хэвшлийн 230 компани оролцсон.



НЭГТГЭЛД ОРУУЛСАН КОМПАНИУДЫГ СОНГОХ АРГАЧЛАЛ

2017 онд улсын төсөвт төлсөн нийт төлбөр, орлогын 98.8%, орон нутгийн төсөвт шилжүүлсэн төлбөр орлогын 96.4%-ийг нь

100 сая төгрөгөөс дээш татвар, төлбөр, хураамж төлсөн 277 компани эзэлж байна.



Эдгээр 277 компанийн Засгийн газарт (улсын болон орон нутгийн) төлсөн төлбөр нь нийт дүнгээрээ 2,152.4 тэрбум төгрөг буюу Засгийн газрын хүлээн авсан нийт орлогын 98.8%-ийг эзэлж байна. Эдгээр 277 компаниас 230 компанийг сонгохдоо дараах шалгуур үзүүлэлтийг харгалзан үзэж, сонголтыг хийсэн.

МЭДЭЭЛЛИЙН НАЙДВАРТАЙ БАЙДАЛ

ОТАХ нь тайлан гаргасан байгууллагуудаас найдвартай байдлын баталгаа авсан талаар

мэргэжлийн дүгнэлт гаргуулахыг Хараат бус хянагч-нэгтгэгчээс шаарддаг.


Мэдээлэл ирүүлэх ёстой	Засгийн газрын байгууллага - 10	Төрийн өмчит аж ахуйн нэгж - 11	Хувийн компани - 219
	бүгд ашигласан	бүгд ашигласан	177 компани ашигласан
Цахим тайлагналын систем	бүгд ашигласан	бүгд ашигласан	177 компани ашигласан
Удирдлагын хариуцлагын захидал	3 ирүүлээгүй	2 ирүүлээгүй	24 ирүүлээгүй
Аудиторын мэдэгдэл*	Засгийн газрын байгууллагууд нь ОУИТБС-ын цахим тайлагналын системд оруулж тайлагнасан тоон мэдээллээ баталгаажуулсан аудиторын мэдэгдлийг ирүүлээгүй.	7 компани ирүүлээгүй	98 компани ирүүлээгүй
Аудитлагдсан санхүүгийн тайлан		3 ирүүлээгүй. Үүнд: • Тавантолгой ХК • Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ХК • Баянтээг ХК	146 компани нь аудитлагдсан санхүүгийн тайлан-гийн хуулбар ирүүлсэн. Үүнээс 8 компани хязгаарлалттай дүгнэлт авчээ.

* Баталгаажуулах Ажлын Олон Улсын Стандарт (ISAE)-ын дагуу баталгаажуулалтын тайлан

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ

Хараат бус хянагч-нэгтгэгч нь МОУИТБС-ын цахим тайлагналын системийг ашиглан төлбөр орлогын мэдээлэл болон орлогын бус мэдээллийг цуглуулсан. Төрийн байгууллагаас

тайланд орох уул уурхайн салбарын талаарх үндсэн мэдээлэл, статистик тоон мэдээллүүдийг авсан. Цахим тайлангийн систем дэх талуудын оролцооны байдал:



ТОДОРХОЙЛОЛТ

- **Орлогын мэдээлэл:** Засгийн газрын байгууллагуудын хүлээн авсан татвар, төлбөр, хураамжийн орлогуудын мэдээлэл
- **Төлбөрийн мэдээлэл:** Цахим тайлагналын системд уул уурхайн компанийн улсын болон орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, хураамжийн мэдээлэл
- **Орлогын бус мэдээлэл** (Төрийн байгууллагын): Стандартын шаардлагын дагуу нэгтгэл ажлын цар хүрээнд яам, Тамгын газар, хэрэгжүүлэгч агентлагуудаас баталгаатай эх үүсвэртэй цуглуулсан мэдээлэл
- **Нэмэлт мэдээллийн маягт:** ОУИТБС-ын Стандарт 2016 болон ОТАХ-ийн саналын дагуу Олборлох үйлдвэрлэлийн салбарын ААН-үүд цахим тайлангийн системд оруулж, ил тод болгодог нэмэлт мэдээллийн маягт


- **Орлогын бус мэдээлэл** (Нэгтгэлд хамрагдсан уул уурхайн компаниудын): Нэгтгэл тайланд тусгагдсан стандарт болон ОТАХ-ийн саналын дагуу уул уурхайн компаниудтай холбоотой ил тод болгох мэдээлэл
- **Цахим тайлангийн өгөгдлийн сан:** Тайланд оролцогч талууд холбогдох тайлан мэдээллээ цахимаар тайлагнаж, МОУИТБС-ын хүрээнд ил тод болж буй мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, мэдээллийг ил тод болгох зорилготой цахим хуудсанд суурилсан програм хангамж
- **МОУИТБС-ын ажлын алба:** ОУИТБС-ын үндсэн зарчмуудыг хэрэгжүүлэх бэлтгэлийг хангаж, тогтворжуулахад Үндэсний зөвлөл болон ажлын хэсэгт туслах, Үндэсний зөвлөлийн шийдвэрийг үр дүнтэй, үр нөлөөтэй хэрэгжүүлэх чиг үүрэгтэй, 5 орон тооны бүрэлдэхүүнтэй ажлын алба

БҮЛЭГ 3. НЭГТГЭЛИЙН ҮР ДҮН

ХУРААНГУЙ

Төлбөр, орлогын анхны нэгтгэлээр нийт 122.5 тэрбум төгрөгийн цэвэр зөрүү үүссэн ба Хараат бус хянагч-нэгтгэгч Засгийн газрын тайланд 61.8 тэрбум, компанийн дүнд 184.5

тэрбум төгрөгийн нэмэгдэх тохируулгыг цэвэр дүнгээр тус тус хийж, 236.2 сая төгрөгийн тайлбарлагдаагүй зөрүү үүссэн.



Төрийн байгууллагуудын тайлагнасан нийт орлогын тохируулсан дүн болон хамгийн их төлбөр төлсөн 10 компанийн тохируулгын дараах төлбөрийн дүнд эзлэх хувийг харуулав. 2017 онд олборлох үйлдвэрлэлийн топ 10



компанийн төлсөн төлбөрийн дүн нь олборлох үйлдвэрлэлийн компаниудаас Засгийн газрын хүлээж авсан нийт орлогын 85.6%-ийг бүрдүүлсэн байна.




НЭГТГЭЛИЙН ҮР ДҮН - ЗАСГИЙН ГАЗРЫН ОРЛОГЫН УРСГАЛААР

МОУИТБС-ын цахим тайлагналын системд бүх компаниуд шаардлагатай мэдээллээ оруулаагүй учир зөрүүгийн материаллагийн түвшинтэй харгалзуулан, бүх материаллаг урсгалыг хамруулан системийн бүх урсгалыг

оруулахаар шийдвэрлэсэн. Нийт улсын түвшний 32 орлогын урсгалаас хамгийн материаллаг гэж үзэж буй 20 орлогын урсгалыг сонгоход нийт урсгалын 99.96%-ийг эзэлж байна.

		Тэрбум төгрөг	Зөрүү сая төгрөг
НИЙТ НЭГТГЭЛИЙН ДҮН			
НИЙТ 2,086.5 тэрбум	УЛСЫН ХЭМЖЭЭНИЙ НЭГТГЭЛИЙН ДҮН	2,206.9	(236.2)
ОРЛОГЫН УРСГАЛ			
Татвар 879,9 тэрбум 	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	418.0	(0.2)
	Гаалийн албан татвар	50.6	5.4
	Нэмэгдсэн өртгийн албан татвар	202.2	13.9
	Автобензин, дизелийн түлшний татвар	0.1	0.0
	Аж ахуйн нэгжээс төлсөн ажиллагчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	162.9	0.0
	Торгууль	1.7	(14.2)
Төлбөр 1,127.6 тэрбум 	Бусад	44.3	(18.6)
	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр	815.0	0.0
	Ашигт малтмал ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	23.4	(0.7)
	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	4.1	0.0
	Бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой төлбөрүүд	203.6	0.0
	Газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	3.0	0.0
	Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	11.1	42.5
	Агаарын бохирдлын төлбөр	34.8	0.0
	Рояльти	31.7	0.0
	БОАЖЯ-ны тусгай дансанд төвлөрүүлсэн байгаль хамгаалах зардлын 50%-ийн хэмжээ	1.0	(138.4)
Хандив 18.4 тэрбум 	Төрийн байгууллагад өгсөн хандив, дэмжлэг	18.4	(15.7)
Хураамж 60.6 тэрбум 	Гаалийн үйлчилгээний хураамж	60.6	(65.9)



Нийт орон нутгийн түвшний 13 орлогын урсгалаас бусад гэж тайлагнасан урсгалыг хасаж, 12 орлогын урсгалыг сонгоход, нийт урсгалын 93.57%-ийг эзэлж байна. Нэгтгэлийн

тайланд доорх хүснэгтэд дурдсан 12 орлогын урсгалыг орон нутгийн түвшинд хамруулахаар болсон.

		Тэрбум төгрөг	Зөрүү сая төгрөг
НИЙТ 120.3 тэрбум	ОРОН НУТГИЙН ХЭМЖЭЭНИЙ НЭГТГЭЛИЙН ДҮН	120.3	(44.3)
	ОРЛОГЫН УРСГАЛ		
Татвар 35.8 тэрбум	 30% Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	29.6	 0.0
	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	1.2	 (24.5)
	Торгууль	2.3	 (4.1)
	Бусад	2.7	 (6.0)
Төлбөр 84.5 тэрбум	 70% Газрын төлбөр	14.5	 (8.3)
	Ус ашигласны төлбөр	42.3	 0.0
	Ус бохирдуулсны төлбөр	0.1	 0.0
	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	1.6	 0.2
	Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	0.4	 0.0
	Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хүлээн авсан орон нутгийг хөгжүүлэх урамшуулал	2.1	 0.0
	Орон нутийн төрийн өмчийн ногдол ашиг	23.5	 0.0
	Нөхөн төлбөр	0.1	 0.0
	Байгаль хамгаалах зардлын 50%-ийг тусгай дансанд шилжүүлсэн дүн	0.1	 (1.5)

БҮЛЭГ 4. ОЛБОРЛОХ САЛБАР САЛБАРЫН ТОЙМ

I. Олборлох үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулдаг компани болон ажилчид



II. Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл



Хайгуулын тусгай зөвшөөрөл
2,046
9,266,907.56 га газар




Ашиглалтын тусгай зөвшөөрөл
1,637
1,559,249.12 га газар

III. Олборлох салбарын эдийн засагт оруулж буй хувь нэмэр




УУЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТ



ДНБ-д уул уурхайн эзлэх хувь



Нийт аж үйлдвэрлэлд УУУ-ийн эзлэх хувь



Улсын төсвийн нийт орлогод олборлох салбарын эзлэх хувь

IV. Уул уурхайн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

2,461.4 тэрбум



Нүүрс
олборлолт

927.2 тэрбум



Газрын тос
олборлолт

5,883.4 тэрбум



Металлын
хүдэр олборлолт

116.8 тэрбум



Бусад ашигт
малтмал олборлолт

V. Экспортод гаргасан гол нэр төрлийн эрдэс бүтээгдэхүүн

Боловсруулаагүй, хагас
боловсруулсан алт



Зэсийн
баяжмал

Төмрийн хүдэр,
баяжмал, пирит

Цайрын баяжмал


Нүүрс

Боловсруулаагүй
нефть



VI. Хог хаягдал, ашигласан усны мэдээлэл

39.9
Энгийн хог
хаягдлын хэмжээ
(мян.метр.куб)



3.2
Аюултай хог
хаягдлын хэмжээ
(мян.метр.куб)

Дахин боловсруулсан
1.8 (мян.метр.куб) **55%**

Төлсөн төлбөр - 318.5 сая төгрөг



Гэрээнд заасан ашиглах
усны хэмжээ (сая.метр.куб)

68.2 (сая.метр.куб) **Нийт ашигласан**



8.0 (сая.метр.куб) **Гадаргын**




60.2 (сая.метр.куб) **Газар доорх**

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГТ ОРУУЛСАН ХУВЬ НЭМЭР

Уул уурхайн салбар Монгол Улсын эдийн засагт 2017 оны байдлаар Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ий 23.4%, аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүний 73%, нийт

4.9 тэрбум ам.долларын экспортын орлогыг бий болгосон нь экспортын 79.6%, нийт гадаадын хөрөнгө оруулалтын 72%-ийг эзэлж байна.




Эх сурвалж: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан


Монгол Улс 2017 онд дэлхийн 163 улстай худалдаа хийж, гадаад худалдааны нийт бараа эргэлт 10.5 тэрбум ам.доллар, үүнээс экспорт 6.2 тэрбум ам.доллар, импорт 4.3 тэрбум ам.долларт хүрчээ. Экспорт 2017 онд өмнөх оноос 1.3 тэрбум ам.доллараар өсөхөд эрдэс бүтээгдэхүүний экспорт 1.4

тэрбум ам.доллар, үүнээс нүүрсний экспорт 1.3 тэрбум ам.доллараар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Монгол Улсын төсвийн нийт орлогын 24%-ийг олборлох салбараас бүрдүүлж байна.



Эх сурвалж: ЯАГ, МУ-ын 2017 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, 2018



Газрын тосны Тамсаг, Тосон-Уул, Зүүнбаянгийн ордуудын баталгаат нөөцийг 332.64 сая тонн, ашиглалтын баталгаат нөөцийг 43.2 сая тонноор тогтоосон байдаг.


Тамсаг, Тосон-Уул, Зүүнбаянгийн ордуудаас 1996-2017 оны хооронд нийт 51.44 сая баррель буюу 6.95 сая тонн тос олборлож, 49.0 сая баррель буюу 6.62 сая тонн газрын тос экспортлон Улсын төсөвт 1.3 их наяд орчим төгрөгийг төвлөрүүлжээ.

■ Газрын тосны олборлолт (мянган баррель)
 ■ Экспорт (мянган баррель)
 —○— Улсын төсөвт төвлөрүүлсэн орлого (тэрбум төгрөг)

АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР

2017 онд уул уурхайн бүтээгдэхүүний зах зээлийн үнэ болон биет хэмжээ өссөн нь АМНАТ-аас Төсвийн тогтворжуулалтын санд 297.4 тэрбум, Ирээдүйн өв санд 357.7 тэрбум,

улсын төсөвт 192.6 тэрбум, нийт 847.7 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлэх боломжийг бий болгосон байна.



Уул уурхайн салбараас 2017 онд улсын төсөвт төвлөрүүлсэн АМНАТ-ийн 88.3%-ийг зэс, нүүрсний салбарын, 11.7%-ийг бусад уул уурхайн бүтээгдэхүүний татварын орлого


тус тус эзэлж байна. Үүний 56.6% буюу 479.5 тэрбум төгрөг нь зэсийн баяжмал, 31.7% буюу 269.1 тэрбум төгрөг нь нүүрсний үйлдвэрлэлээс төвлөрчээ.



АШИГТ МАЛТМАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ЭКСПОРТ

Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ жилээс жилд өсөн нэмэгдэж байна.

Эрдэс бүтээгдэхүүний экспорт (сая ам.доллар)



Уул уурхай, олборлох аж үйлдвэрийн гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ дараах байдалтай байна. Үүнд:

Ашигт малтмалын төрөл		Хэмжих нэгж	2013	2014	2015	2016	2017
1	Зэсийн баяжмал (металл агуулгаар)	мян.тн	533.3	712.0	890.7	1,445.1	1,317.1
2	Молибдений баяжмал (металл агуулгаар)	тн	3,869.2	4,254.0	5,441.0	5,173.7	5,616.7
3	Алт	кг	8,904.4	11,503.8	14,556.2	18,435.7	19,846.8
4	Хайлуур, жоншны баяжмал	мян.тн	76.4	374.9	230.8	34.1	55.2
5	Төмрийн хүдрийн баяжмал	мян.тн	6,011.2	10,260.5	6,173.4	2,209.9	3,675.0
6	Цайрын баяжмал	мян.тн	104.1	93.2	89.6	100.2	82.7

Эх сурвалж: УУХҮЯам, Ашигт малтмал, газрын тосны газар, Эрдэс баялгийн статистик мэдээ хуудас 11, 2017 он

АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛ, АШИГЛАЛТ

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 2,225 компанийн 3,708 тусгай зөвшөөрөлтэй талбай дээр 50 төрлийн ашигт малтмалын хайгуулын болон олборлолтын үйл

ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшиж байна. Тайлант онд ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэлд нийт 92 орд бүртгэгдсэн байна.



Эх сурвалж: УУХҮЯ, Ашигт малтмал, газрын тосны газар, Эрдэс баялгийн статистик мэдээ, хуудас 10, 2017 он

2017 онд Улсын төсвийн хөрөнгөөр 29 аж ахуйн нэгжийн 48 төсөл хэрэгжүүлсэн бол хувийн хөрөнгөөр хайгуулын ажил

гүйцэтгэгч зөвшөөрөлтэй компаниудаас 1,538 гүйцэтгэлийн тайлан ирүүлсний 1,278 нь баталгаажсан байна.



ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ҮЙЛ ЯВЦ

Ашигт малтмалын тухай хууль болон Газрын тосны тухай хуулинд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаатай холбоотой дараах гол зохицуулалтууд орсон байдаг.

ОРОЛЦОГЧ ТАЛ



ТӨР



ХУВИЙН ХЭВШИЛ

АШИГТ МАЛТМАЛ

Судалгаа хийж буй талаар АМГТГ болон Аймаг, нийслэлийн засаг дарга нарт мэдэгдэнэ.

АМГТГ тогтоогдсон нөөцийг бүртгэхдээ ИТХ-ын шийдвэрийг харгалзана.

Хувийн болон улсын зардлаар

Сонгон шалгаруулалт буюу тендер зарлана.

Хайгуулын тусгай зөвшөөрөл 3 жилээр олгоно.
(3 жилээр 3 удаа сунгана)

Ердийн орд газрын хайгуулыг тендерт шалгарсан хуулийн этгээд хувийн зардлаар хийнэ.

Хайгуулаа хувийн зардлаар хийсэн хуулийн этгээд давуу эрхтэйгээр хүсэлт гаргаж тусгай зөвшөөрөл авна. Бусад тохиолдолд сонгон шалгаруулалт хийнэ.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл 30 жил (нөөцөөс хамааран 20 хүртэл жилээр сунгана).

Стратегийн ач холбогдолтой ашигт малтмалын ордыг ашиглавал төрийн оролцоо 50% хүртэл байж болно. Ердийн орд газрын ашиглалт тендерт шалгарагчийн зардлаар хийнэ.

Судалгаа



ГАЗРЫН ТОС

АМГТГ-тай 3 жилийн хугацаатай Эрлийн гэрээ байгуулна.
(өрөмдлөг хийж болно)

Эрлийн ажлын үр дүнгийн тайлан мэдээ

Хувийн болон улсын зардлаар

Эрэл хийсэн этгээд БХГ-ний төслөө АМГТГ-т ирүүлнэ. Бусад тохиолдолд сонгон шалгаруулалт хийнэ.

АМГТГ хайгуулын тусгай зөвшөөрөл буюу БХГ-г 8 жилээр байгуулна.
(2 удаа тус бүр 2 жилээр сунгана)

Хувийн болон улсын зардлаар

Хайгуул



Ашиглалт



Хайгуулаа хувийн зардлаар хийсэн хуулийн этгээд давуу эрхтэйгээр хүсэлт гаргаж тусгай зөвшөөрөл авна. Бусад тохиолдолд сонгон шалгаруулалт хийнэ.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл буюу БХГ-г газрын тос - 25 жил (5 хүртэлх жилээр 2 удаа), уламжлалт бус газрын тос - 30 жилээр олгоно. (5 хүртэлх жилээр 1 удаа сунгана)

Ашиглалтыг хувийн зардлаар санхүүжүүлнэ.



НӨХӨН
СЭРГЭЭЛТ

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ

Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журмыг УУХҮЯ-ны сайдын 2018 оны А/28 дугаар тушаалаар өөрчлөн, баталсан. Лиценз олгоход ашигладаг техникийн болон санхүүгийн шалгуур үзүүлэлтүүд:



- Геологи хайгуулын ажил 15 оноо
- Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн төлөвлөлт, ажлын нэр төрөл, түүнд зарцуулах зардлын хэмжээ, хэрэгжүүлэх хугацаа 6 оноо
- Орон нутгийг хөгжүүлэх, хамтран ажиллах төлөвлөгөө 4 оноо

2017 онд шинээр олгосон болон шилжүүлсэн тусгай зөвшөөрлүүд (шаардлага 2.2.а.iii)-ийн тоо баримтыг дор харууллаа.



Хайгуулын тусгай зөвшөөрөл



Ашиглалтын тусгай зөвшөөрөл




Сонгон шалгаруулалт

Эх сурвалж: УУХҮЯ-н, Ашигт малтмал, газрын тосны газар, 2017 оны Эрдэс баялгийн статистик мэдээ, хуудас 25

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ХАНДИВ, ОРОН НУТГИЙН САНХҮҮЖИЛТ

Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн 69.6%-д ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгогдох боломжтой байна. 2018 оны эхний улирлын байдлаар нийт нутаг дэвсгэрийн 8%-д тусгай зөвшөөрөл олгогдоод байна.



Жич: Тусгай зөвшөөрлийн тоо болон талбайн хэмжээнд хайгуулын түгээмэл тархацтай ашигт малтмал болон газрын тосны тусгай зөвшөөрлийн мэдээлэл ороогүй болно.

Аймаг, нийслэлийн ОНХС-д 2017 онд олгох орлогын шилжүүлгийн санхүүжилт (тэрбум төгрөг)

Тусгай зөвшөөрөлтэй компаниас орон нутагт олгосон мөнгөн болон мөнгөн бус хандив (сая төгрөг)

Хайгуулын тусгай зөвшөөрөл

Ашиглалтын тусгай зөвшөөрөл

ЭНГЭ

687 2.1

Лиценз 58
Талбай (га) 89.4
141 37.4

ДАРХАН-УУЛ

Лиценз 29
Талбай (га) 1.7

ХЭНТИЙ

Лиценз 61
Талбай (га) 2.0

ДОРНОД

Лиценз 56.8
Талбай (га) 2.1

БУЛГАН

Лиценз 429
Талбай (га) 1.7

Лиценз 15
Талбай (га) 11.4
67 6.3

Лиценз 155
Талбай (га) 508.5
107 40.7

Лиценз 115
Талбай (га) 539.2
69 57.2

УЛААНБААТАР

Лиценз 76
Талбай (га) 11.8

СҮХБААТАР

Лиценз 173
Талбай (га) 1.6

Лиценз 56
Талбай (га) 209.0
67 34.3

Лиценз 16
Талбай (га) 1.6
169 12.5

Лиценз 51
Талбай (га) 464.5
61 49.9

ГОВЬСҮМБЭР

Лиценз 2.8
Талбай (га) 1.2

Лиценз 508
Талбай (га) 1.8
155 390.8
305 143.2

Лиценз 5
Талбай (га) 20.0
12 38.7

ДУНДГОВЬ

Лиценз 126.2
Талбай (га) 1.8

Лиценз 136
Талбай (га) 823.3
95 156.1


ДОРНОГОВЬ

Лиценз 892
Талбай (га) 2.3

Лиценз 249
Талбай (га) 1,559.7
170 213.8

Лиценз 3.2
Талбай (га) 123.3
532.7

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн бүтэц, ашигт малтмалын төрлөөр




ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ БАЙГУУЛЛАГУУДЫН ТОО БАРИМТ

2017 оны жилийн эцсийн байдлаар ашигт малтмалын 10 ба түүнээс дээш тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн жагсаалтыг харуулав.



2017 оны жилийн эцсийн байдлаар ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий 1,000 ба түүнээс дээш км² талбайг эзэмшигчдийн жагсаалт



БИЧИЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧИД

Гар аргаар ашигт малтмал олборлох буюу Бичил уул уурхай гэдэг нь Монгол Улсын нутаг дэвсгэрт нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан иргэдийн (ихэвчлэн хууль бус) эрхэлж буй ашигт малтмал олборлох үйл

ажиллагааг хэлнэ. Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-аар зохицуулж байна.

11,962



Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчид:

Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчид болон ам бүлийн гишүүдээс оролцож буй

9,596



Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчид:

Бичил уурхайн үйл ажиллагаанд оролцогчид (ашигт малтмал худалдан авагч, тээвэрлэгч иргэд орсон)

6,948



Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчид:

Бичил уурхайн үйл ажиллагаа эрхлэгчид (олборлолт болон туслах үйл ажиллагаа эрхэлж буй иргэд)

5,998



Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхлэгчид:

Бичил уурхайн олборлолтын үндсэн үйл ажиллагаа эрхэлж буй иргэд

5,998 БИЧИЛ УУРХАЙ ЭРХЛЭГЧДИЙН



86.8%
Эрэгтэй



13.2%
Эмэгтэй



51.3%
Даатгалд
хамрагдсан



48.7%
Даатгалд
хамрагдаагүй



349.8 сая төгрөг
Төлсөн татвар



332 цэг
Орд газар



382.8 Га
Нөхөн сэргээлт
хийсэн талбай



685 хүн
Нөхөн сэргээлт
хийсэн

Эрх зүйн орчинтой болсноор:

Төрийн үйлчилгээ авах боломжтой болж, нөхөн сэргээлт хийдэг болсон. Хүдэр баяжуулах цехээр алт ялгуулснаар мөнгөн усны хэрэглээ буурсан.

Зохион байгуулалтад орсноор:

Бичил уурхайн дээвэр холбоонд нэгдэж, нөхөрлөл байгуулж ажиллаж байна. Дээвэр холбоонд 15 аймгийн 428 нөхөрлөлийн 6,300 гаруй бичил уурхай эрхлэгчид бүртгэлтэй байна.

Алтны гарал үүслийг тодорхой болгох:

Европын Холбоо 2021 оноос гарал үүсэл нь тодорхой алт, бусад гурван төрлийн ашигт малтмалыг худалдан авахыг мэдэгдсэн. Монголбанкнаас алтны дотоодын худалдан авалтанд гэрээ байгуулах бодлого төлөвлөсөн.

Нөхөн сэргээлт нэмэгдлээ:

Бичил уурхай эрхлэгчдийн хийж буй нөхөн сэргээлтийн талбай нь 2012 онд эвдрэлд орсон нийт талбайн 7.2% байсан бол 2016 онд 11.9% болж өссөн байна.

Амьжиргаанд өөрчлөлт орлоо:

Бичил уурхай эрхэлснээр давхардсан тоогоор 3,753 иргэд амьжиргааны орлогын эх үүсвэртэй, 610 иргэд байнгын ажлын байртай, 766 нь хувийн тээврийн хэрэгсэлтэй, 248 нь сууцтай болжээ.

Төрийн үйлчилгээ, төсөл, хөтөлбөрт хамрагддаг болсон:

Бичил уурхай эрхлэгчид орлоготой болж улсад татвар төлж, нийгмийн даатгал болон төрийн үйлчилгээнд хамрагдах боломжтой болсон. Судалгаагаар 1,032 уурхайчин төрийн болон ТББ-ын тусламж, дэмжлэгт хамрагдсан.

ГАЗРЫН ТОС БА БАЙГАЛИЙН ХИЙ


Газрын тосны тухай хуулийн дагуух нэр томъёогоор “Газрын тос” гэдэгт түүхий тос, байгалийн хий орно. Мөн АМГТГ нь байгалийн

хийн талаар ямар нэгэн гэрээ хэрэгжүүлээгүй ба байгалийн хийн эрэл, хайгуулын ажил явагдаагүй байна.

Газрын тосны лиценз

Монгол улсын нутаг дэвсгэрт 2017 оны байдлаар 18 талбайд газрын тос, уламжлалт бус газрын тосны эрлийн гэрээ, 25 талбайд


бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа явуулж байна.



Бүтээгдэхүүн хуваах гэрээ

“Бүтээгдэхүүн хуваах гэрээ” гэж газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаа эрхлэх талаар


газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, гэрээлэгчийн хооронд байгуулсан гэрээг хэлнэ.



Эх сурвалж: АМГТГ-ын Геологи, хайгуулын хэлтэс

Газрын тосны бүтээгдэхүүний импорт

Бүтээгдэхүүний нэр төрөл	Нийт (мян.тн)
90-ээс доош октантай автобезин	61.6
90-ээс дээш октантай автобензин	365.2
Дизелийн түлш	838.6
ТС-1	36.2
Бусад (тос, мазут, битум хий)	187.4
Нийт дүн	1,499.0



Эх сурвалж: АМГТГ-ын Газрын тосны ашиглалтын хэлтэс, Газрын тосны бүтээгдэхүүний хэлтэс

ГАЗРЫН ТОСНЫ ОЛБОРЛОЛТ, ЭКСПОРТ

Газрын тос олборлож буй 3 талбайд 2 компани үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Пэтрочайнагийн охин компани болох

“Пэтрочайна Дачин Тамсаг” ХХК нь газрын тосны дийлэнх хувийг олборлож экспортод гаргадаг.

	Гэрээлэгч компани	Доншен газрын тос Монгол ХХК	Петрочайна Дачин Тамсаг ХХК	
	Ашиглалтын талбайн нэр	БХГ-97	Тамсаг-XXI	Тосон-Уул XIX
	Гэрээ байгуулсан он	1997	1995	1993

Засгийн газарт ногдох газрын тосны борлуулалтын орлого (тэрбум төгрөг)



Газрын тосны нөөц ашигласны төлбөр (тэрбум төгрөг)



Нийт Орлого (тэрбум төгрөг)




Петрочайна Дачин Тамсаг ХХК

Доншен газрын тос Монгол ХХК



2017 оны Газрын тосны олборлолт

Эх сурвалж: АМГТГ-ын Геологи, хайгуулын хэлтэс



ГАЗРЫН ТОСНЫ ХАЙГУУЛ

Дараах хүснэгтэд 2017 онд хувийн хөрөнгөөр санхүүжүүлсэн газрын тосны хайгуулын төслүүдийн үйл ажиллагааг харууллаа.



Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт газрын тосны олборлолтыг тогтвортой нэмэгдүүлэн, газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах зорилт дэвшүүлсэн байна.

Энэхүү зорилтын хүрээнд ЗГ-ын 2017 оны 92 дугаар тогтоолоор газрын тос боловсруулах үйлдвэрбарихтөслийгхэрэгжүүлэхүүрэгбүхий

төрийн өмчит компани байгуулах шийдвэр гарч, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” төрийн өмчит ХХК-ийг ТӨБЗГ-ын 2017 оны 108-р тогтоолоор байгуулж, улмаар жилд 1.5 сая тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай үйлдвэр барих нарийвчилсан техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулан ажиллаж байна.

УРАНЫ ТУХАЙ

2017 оны жилийн эцсийн байдлаар хүчин төгөлдөр ураны тусгай зөвшөөрлүүдийн мэдээллийг дор харуулав. Тайлант онд ашигт

малтмалын нөөцийн нэгдсэн санд ураны нөөц нэмж бүртгэгдээгүй байна.



ЗАСГИЙН ГАЗРЫН БАЙГУУЛЛАГУУД

Олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хамгийн их оролцоотой Засгийн газрын байгууллагууд болон тэдгээрийн ажил үүргийн ерөнхий чиглэлийг дор харуулав.



Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам

- Ил тод, хариуцлагатай уул уурхай, хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлэх
- Эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах
- Эдийн засгийн тэнцвэртэй олон тулгуурт бүтцийг бий болгох



Ашигт малтмал, газрын тосны газар

- Эрдэс баялгийн салбарын хөгжлийн бодлого боловсруулахад дэмжлэг үзүүлэх
- Хөрөнгө оруулагчид, хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлэх
- Үндэсний эдийн засгийн хөгжилд салбарын үүргийг нэмэгдүүлэх



Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

- Хөдөлмөр, хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын харилцан хамаарал бүхий цогц бодлогыг хэрэгжүүлэх
- Иргэдийн хөдөлмөрлөх, хөгжих таатай орчин бий болгох
- Нийгмийн баталгааг дээшлүүлэх замаар хүний хөгжлийг хангах



Гаалийн ерөнхий газар

- Үндэсний аюулгүй байдлыг хамгаалах
- Олон улсын хууль ёсны худалдааг хөнгөвчлөх
- Улсын төсвийн орлогыг бүрдүүлэх, байгууллагын чадавхийг бэхжүүлэх



Үндэсний аудитын газар

- Төрийн эрх барих дээд байгууллагын үүргээ хэрэгжүүлэхэд нь Улсын Их Хуралд дэмжлэг үзүүлэх
- Эх орон, ард түмний эрх ашгийн төлөө Засгийн газрын хүлээх хариуцлага, үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөөг дээшлүүлэхэд тусална.



Байгаль орчин, аялал жуулчлалын яам

- Хөгжлийн хандлагыг экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байхад чиглүүлэх
- Байгалийн нөөц баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх
- Байгалийн тогтвортой байдал, ногоон хөгжлийг хангахад төр, иргэн, ААНБ-ын түншлэлийг бэхжүүлэх
- Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах
- Байгальд ээлтэй, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар

- Төрийн өмчийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх
- Төрийн өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх
- Худалдан авах ажиллагааг олон улсын жишигт хүргэн ил тод, өрсөлдөх тэгш боломжийг хангах



Цөмийн энергийн комисс

- Монгол Улсад цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийг энхийн зорилгоор ашиглах
- Цөмийн технологи нэвтрүүлэх судалгааг хөгжүүлэх
- Цөмийн болон цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах
- Хүний нөөцийг бэлтгэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх



Татварын ерөнхий газар

- Татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
- Татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт, сурталчилгаа явуулах
- Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих
- Улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх

ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭ БА ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГУУД

Олборлох салбарын гол хуулиуд болон салбарын харилцааг зохицуулж буй бусад хуулиудыг багцлан дор харуулав.



САЛБАРЫН ГОЛ ЗОХИЦУУЛАХ ХУУЛИУД

- Ашигт малтмалын тухай хууль, 2006
- Газрын хэвлийн тухай хууль, 1988
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, 2014
- Цөмийн энергийн тухай хууль, 2009
- Газрын тосны тухай хууль, 2014
- Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль, 2005
- Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль, 2009
- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль, 2013
- Цөмийн энергийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, 2009
- Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, 2009



ТӨСӨВ, ТАТВАРЫН ЧИГЛЭЛИЙН ХУУЛИУД

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, 2006
- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль, 2008
- Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, 2017
- Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хууль, 2012
- Ирээдүйн өв сангийн тухай хууль, 2016
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, 2006, 2015
- Татварын ерөнхий хууль, 2008
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, 2010
- Үл хөдлөх эд хөрөнгийн татварын тухай хууль, 2000
- Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, 2010



БИЗНЕСИЙН ХАРИЛЦАА, ОРЧНЫ ЧИГЛЭЛИЙН ХУУЛИУД

- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, 2001
- Захиргааны ерөнхий хууль, 2015
- Хөрөнгө оруулалтын тухай хууль, 2013
- Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, 2015

ОУИТБС-ЫГ МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖҮҮЛЭХ ХҮРЭЭНД ГАРСАН ЭРХ ЗҮЙН БАРИМТ БИЧГҮҮД

- Нийт 6 хуульд нэмэлт, өөрчлөлтүүд орсон байна. Үүнд: Ашигт малтмалын тухай хууль, Цөмийн энергийн тухай хууль, Газрын тосны тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль.
- Ерөнхий сайдын захирамж болон холбогдох яамдын сайдын тушаал, шийдвэрээр 15 гаруй дүрэм, журам, санамж бичиг, төлөвлөгөө батлагдав.
- Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 381 дүгээр тогтоолоор Нээлттэй засгийн түншлэлийн 2 дахь шатны үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө (2016-2018)-г батлан байгалийн баялгийг ашиглах бенефициар өмчлөгчийн мэдээллийн ил тод байдлыг хангах зорилт дэвшүүлэн ажиллаж байна.
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч болон нутгийн захиргааны байгууллагын хооронд байгуулах хамтын ажиллагааны гэрээний загвар, мөн 2015 оны 104 дүгээр тогтоолоор Бүтээгдэхүүн хуваах гэрээний загварыг баталсан.
- Гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай Засгийн Газрын тогтоол 2016 онд гарсан.



БАЙГАЛЬ ОРЧНЫ ЧИГЛЭЛИЙН ХУУЛИУД

- Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, 2010
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2012
- Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, 2012
- Газрын тухай хууль, 2002
- Газрын төлбөрийн тухай хууль, 1997
- Ойн тухай хууль, 2012
- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль, 2012



ХАРИУЦЛАГЫН ЧИГЛЭЛИЙН ХУУЛИУД

- Аудитын тухай хууль, 1997
- Зөрчлийн тухай хууль, 2017
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, 2017
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, 2015
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, 2012
- Захиргааны ерөнхий хууль, 2015



ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГУУД

- Төрөөс газрын тосны салбарыг хөгжүүлэх талаар баримтлах бодлого
- Төрөөс цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энергийн талаар баримтлах бодлого
- Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр
- Алт-2 Үндэсний хөтөлбөр (Засгийн газрын 2017 оны 20 дугаар тогтоол)
- Төсвийн бодлого, төсвийн хууль тогтоомж (шаардлага 2.1)



ДҮРЭМ ЖУРАМ



Олборлох үйлдвэрлэлийн салбарт 2017-2018 оны эхний хагас жилийн байдлаар шинэчилсэн болон шинээр гарсан журам, зааврууд:

1. Үүсмэл орд ашиглах тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон үйл ажиллагааны журам, болон Үүсмэл орд ашиглах үйл ажиллагаанд тавих шаардлага, үйл ажиллагаа эрхлэх журам (Засгийн газрын 2017 оны 61 дүгээр тогтоол)
2. Хүнд үйлдвэрийн салбарын инженерүүдэд мэргэшсэн болон зөвлөх инженерийн зэрэг олгох журам (УУХҮ-ийн сайдын 2017 оны А/01 дүгээр тушаал)
3. Эрдэс баялгийн бодлогын зөвлөлийн ажиллах журам (УУХҮ-ийн сайдын 2017 оны А/16 дугаар тушаал)
4. Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам (УУХҮ-ийн сайдын 2017 оны А/129 дугаар тушаал)
5. Геологи, уул уурхайн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журам (УУХҮ-ийн сайдын 2017 оны А/206 дугаар тушаал)
6. Цооногийн каротажийн судалгаанд цацраг идэвхт битүү үүсгүүр ашиглахад мөрдөх цацрагийн аюулгүйн дүрэм (Цөмийн энергийн комиссын 2017 оны 12 дугаар тогтоол)
7. Цацраг идэвхт ашигт малтмалыг олборлох, боловсруулах үйл ажиллагаанд мөрдөх цацрагийн аюулгүй ажиллагааны дүрэм (Цөмийн энергийн комиссын 2018 оны 01 дүгээр тогтоол)
8. Нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журам (Засгийн газрын 2018 оны 5 дугаар тогтоол)
9. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд өртсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажлын үр дүнг хүлээн авах журам (УУХҮ-ийн сайд, БОАЖ-ын сайдын хамтарсан 2018 оны А/50, А/31 тоот тушаал)
10. Орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тавигдах шаардлагын төсөлд хийсэн нөхцөл байдлын дүн шинжилгээ (УУХҮ-ийн сайдын 2018 оны А/07 дугаар тушаал)
11. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын талбайг буцаан өгөх, хүлээн авах журмын төсөлд хийсэн нөхцөл байдлын дүн шинжилгээ (УУХҮ-ийн сайдын 2018 оны А/06 дугаар тушаал)
12. Газрын тосны бүтээгдэхүүний тусгай зөвшөөрөлтэй холбоотой нарийвчилсан журам (УУХҮ-ийн сайдын 2018 оны А/08 тушаал).

ОЛБОРЛОХ САЛБАР ДАХЬ ТӨРИЙН ОРОЛЦОО

Эрдэнэс Монгол ХХК нь Монгол Улсын нутаг дэвсгэрт улсын стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудыг боловсруулах болон эзэмшихэд Засгийн газрын хувьцааг


төлөөлөх зорилгоор байгуулагдсан тусгай зориулалтын компани юм. Эрдэнэс Монгол ХХК, бусад томоохон ТӨААН-үүд болон ОНӨААН-үүдийн мэдээллийг дор харуулав.



ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН НЭГЖИЙН САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

Төрийн өмчит ААН-ийн санхүүгийн мэдээлэл Засгийн газар болон ТӨААН-үүдийн хоорондын харилцааг Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хууль болон хуулийн дагалдах Төрийн

өмчийг хэрэгжүүлэх журмуудаар зохицуулдаг. Орон нутгийн өмчит хувьцаат компаниуд нь ногдол ашгийн мэдээллээ дараах байдлаар ирүүлсэн.



Төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагууд	Тайлант хугацаанд хийгдсэн хөрөнгө оруулалт (сая төгрөг)			
	Аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгөөр	Банкны зээл	Бусад эх үүсвэр	Нийт
Багануур ХК	66,114.0	4,002.0	13,678.0	83,794.0
Баянтээг ХК	781.0			781.0
Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХК	7,757.0	16,719.0		24,475.0
Монголросцветмет ХХК	9,348.0			9,348.0
Тавантолгой ХК	3,850.0			3,850.0
Шивээ-овоо ХК	3,767.0			3,767.0
Эрдэнэс монгол ХХК	1,446.0			1,446.0
Эрдэнэс тавантолгой ХК	3,554.0			3,554.0
Эрдэнэт үйлдвэр ХХК	162,492.0			162,492.0
Нийт	259,109.0	20,721.0	13,678.0	293,508.0

Эх сурвалж: Компаниудаас ирүүлсэн мэдээлэл

ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН ТӨААН-ҮҮДИЙН САНХҮҮГИЙН ХАРИЛЦАА



Засгийн газар болон Монгол Улсын Хөгжлийн банкнаас уул уурхай, газрын тосны төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдэд олгосон зээл, зээлийн баталгааны мэдээллийг харуулав.

Зориулалт: Үйлдвэрлэлийн тасралтгүй үйл ажиллагааг хангах

Зориулалт: Өвөлжилтийн бэлтгэл ажил, засвар үйлчилгээнд


ТӨААН-үүдийн төсвийн шинжтэй зарцуулалт

Нэгтгэлд хамрагдсан 11 ТӨААН-үүдээс төсвийн шинжтэй зарцуулалтын мэдээг хүссэн. Үүнээс 5 ТӨААН зарцуулалтыг тайлагнаж, Эрдэнэс монгол ХХК, Эрдэнэс таван толгой ХК, Монголросцветмет ХХК, Улаанбаатар төмөр зам (Чулуун завод) ХНН, Таван толгой ХК, Могойн гол ХК-ууд төсвийн шинжтэй зарцуулалт байхгүй гэж мэдээлсэн.

📍 Зээл олгосон байгууллага ⏰ Зээлийн хугацаа
💰 Зээлийн Хэмжээ % Хүү

Эх сурвалж: Монгол улсын хөгжлийн банк, Компаниудаас ирүүлсэн мэдээлэл

Монгол Улсын Хөгжлийн банкнаас нэгтгэлд хамрагдсан компаниудад олгосон төслийн санхүүжилт



📄 Төсөл хөтөлбөрийн нэр ⏰ Төслийн хугацаа 💰 Гэрээний дүн 📊 Олгосон санхүүжилт (өссөн дүнгээр)

ТӨСВИЙН ҮЙЛ ЯВЦ БОЛОН ОРЛОГО ХУВААРИЛАЛТ

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд төсөв боловсруулах, батлах тухай нарийвчлан заасан бөгөөд төсвийн бүх байгууллага оролцдог, цаг хугацаа, дэс дараалал бүхий нарийн цогц үйл ажиллагаа юм. Төсвийн

захирагч нарын тайланд аудитын дүгнэлт гаргуулах, дээд шатны захирагчид хүргүүлэх, нэгтгэх, улмаар нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг батлах үйл явц, цаглабарыг доор харуулав.



Эх сурвалж. Иргэдийн төсөв - 2018, хуудас 7

ХУВААРИЛАЛТ

- Дотоодын НӨАТ-ын 5%
- АМНАТ-ийн 5%
- Газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 30%
- Олон улсын байгууллагын дэмжлэг

НИЙТ 53.0 тэрбум төгрөг

АМНАТ-аас Төсвийн тогтворжуулалтын санд хуваарилаад үлдсэн хэсгийн 65% болох 357.7 тэрбум төгрөгийг хуримтлуулсан.

Гол нэр төрлийн эрдэс баялгийн тэнцвэржүүлсэн орлого болон нэгдсэн төсвийн суурь орлогоос давсан 325.7 тэрбум төгрөгийг хуваарилсан.

ЗАРЦУУЛАЛТ

Сангаас хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ, орон нутгийн хөгжлийн индекс зэргийг харгалзсан томъёогоор аймаг, нийслэл бүрт ногдохыг шилжүүлсэн

Сангийн удирдлагатай холбоотой корпорацийн зардал, хөндлөнгийн аудитын зардал 160.0 тэрбумыг зарцуулсан.

Дэлхийн зах зээл дээр гол нэр төрлийн эрдэс баялгийн үнэ буурвал тухайн сангаас улсын төсөвт шилжүүлдэг.


Орон нутгийн хөгжлийн сан

Ирээдүйн өв сан

Төсвийн тогтворжуулалтын сан

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.7-д ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогоос 2019 оны төсвийн жилд 50%, 2020 оны төсвийн жилээс эхлэн 100%, 2020 оны төсвийн жилээс эхлэн ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогын 50%-ийг тухайн олборлолт явагдаж байгаа ОНХС-д шилжүүлнэ.


Түүхий нүүрсэнд ногдуулах агаарын бохирдлын төлбөрийн 50%, газрын тосны тусгай зөвшөөрлийн орлогын 30%-ийг нүүрс болон газрын тос олборлож байгаа тухайн аймагт улсын төсвөөс шилжүүлж байгаа тул хуваарилсан хөрөнгийг агаарын бохирдлыг бууруулах, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, ойжуулах үйл ажиллагаанд үр дүнтэй зарцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах ёстой.



Эх сурвалж: Сангийн яам, Төсвийн тухай хууль

БҮЛЭГ 5. БУСАД АСУУДЛУУД ГЭРЭЭНИЙ ИЛ ТОД БАЙДАЛ

Олборлох салбарын ил тод байдлыг зохицуулсан эрх зүйн баримт бичгүүд. Үүнд:



УИХ
Засгийн газар
АМГТГ
Нутгийн захиргааны
байгууллага

Ашигт малтмалын тухай хуульд 2014 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр олборлох үйлдвэрлэлийн салбарт байгуулж байгаа гэрээг төр, засгийн 4 байгууллагад батламжлахаар болсон.

Геологи, уул уурхай, газрын тосны салбарт дараах төрлийн гэрээнүүд байгуулагдаж байна.

- БХГ (газрын тос, занар)
- Концесс
- Тогтвортой байдал
- Хөрөнгө оруулалт
- Нутгийн захиргаатай байгуулсан
- Ашигт малтмалын газартай байгуулсан
- Газрын тосны газартай байгуулсан

БЕНЕФИЦИАР ӨМЧЛӨГЧ

2017 онд анх удаагаа бенефициар эздийг тодорхойлсон бөгөөд 230 компаниас 184 нь маягтыг бөглөж ирүүлсэн бөгөөд 184 компанийн ард 209 хувь хүн, 82 хуулийн этгээд бенефициар өмчлөгчтэй байна.

ОУИТБС-ын стандартын шаардлага 2.5: Компанийн хувьд бенефициар өмчлөгч гэдэг нь тухайн ААН-ийг шууд болон шууд бусаар эзэмшдэг, хянадаг этгээд гэж тодорхойлсон.

Тухайн компанид удирдах албан тушаал хашдаг эсэх:

✓ 137 ✗ 72



Улс төрд нөлөөтэй эсэх:

✓ 5 ✗ 204



Улс төрд нөлөө бүхий этгээд гэж Нийтийн албанд нийтийн болон хувийн эрх ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2-д заасан этгээд

Бенефициар эзэмшигч, иргэншлээр:

Монгол-167	Хонг Конг-2	Казакстан-1
Хятад-27	Япон-2	ОХУ-1
АНУ-2	Малайз-1	Тайван-1
ӨМӨЗО-3	БНСУ-1	Шинэ Зеланд-1

Бенефициар өмчлөгч
209 хувь хүн

Мэдээллээ ирүүлсэн
184 компани

Бүртгэлтэй хөрөнгийн бирж:

Торонто	7
Австрали	6
Хонг Конг	4
Лондон	3
Шанхай	1
Торонто болон Нью Йорк	1
Торонто болон Хонг Конг	1

Харъяалагдах улс:

Хятад - 8
ИБУИВУ - 6
Сингапур - 3
Өмнөд Солонгос - 2
Сейшил - 2
Люксембург - 2
Франц - 2
Австрали - 1
Беларусь - 1
Маршал арал - 1
Самао - 1
Хонг Конг - 1

Нээлттэй компани-23

Хаалттай компани-30

Бенефициар өмчлөгч
82 компани

Дотоодын компани 29

Гадны компани 53

Бүтцээр




Эх сурвалж: Олборлох үйлдвэрлэлийн компаниудаас ирүүлсэн мэдээлэл

ДЭД БҮТЦЭД ХӨРӨНГӨ ОРУУЛАХ БА БАРТЕРЫН СОЛИЛЦОО (ШААРДЛАГА 4.1.D)

Улс орны байгалийн нөөц баялгийг ашиглах эрх олох зорилгоор олборлох үйлдвэрлэлийн компаниуд дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх гэрээг төрийн байгууллагуудтай хийдэг. Ийм гэрээг бартерын солилцооны гэрээ эсвэл “дэд бүтцийг ашигт малтмалаар солилцох гэрээ” гэж нэрлэдэг.



Нэгтгэлд хамрагдсан компаниуд болон төрийн байгууллагуудаас 2017 онд дэд бүтцэд оруулсан хөрөнгө оруулалт ба бартерын солилцооны талаар дараах компаниуд мэдээлэл ирүүлсэн.



Эх сурвалж: Олборлох үйлдвэрлэлийн компаниудаас ирүүлсэн мэдээлэл

ТЭЭВРИЙН ОРЛОГО (ШААРДЛАГА 4.1.F)

Газрын тос, байгалийн хий, байгалийн баялгийн тээвэрлэлтээс олох орлого нь орлогын томоохон эх үүсвэрийн нэг тул Засгийн газар, ТӨААН-үүд ил тод болгох шаардлагатай. Дараах ТӨААН-үүд тээвэрлэсэн бүтээгдэхүүн, тээвэрлэлтийн орлогыг хүлээн авагч төрийн байгууллагуудын талаар тайлагнасан байна.

Компани	Гүйлгээний утга	Орлогыг хүлээн авагч төрийн байгууллага, ТӨААН	Нийт үнэ (сая төгрөг)
“Шивээ овоо” ХХК	Нүүрсний тээвэрлэлтийн орлого	“Дулааны цахилгаан станц 4” ТӨХК	38.9
		“Монголросцветмет” ХХК	0.6
		“Налайх дулааны станц” ТӨХК	0.5
		“Илчлэг шивээ” ОНӨҮГ	0.0
		“Ус-ду” ОНӨҮГ	0.3
		“Чандмань илч” ОНӨУҮГ	0.8
		“Сэлэнгэ Зүүнхараа” ОНӨААҮҮГ	0.2
	Шуудангийн төлбөр	“Монгол шуудан” ХК	1.9
	Тээврийн хөлс	“Улаанбаатар төмөр зам” ХНН	350.0
“Багануур” ХК	Нүүрсний тээвэрлэлтийн орлого	“Улаанбаатар төмөр зам” ХНН	522.0


ЦАХИМ ТАЙЛАГНАЛЫН СИСТЕМ

Одоогоор цахим хуудсаар олон нийт, иргэдэд Монгол Улсын ОУИТБС-ын нэгтгэлийн тайлангуудыг хавсралтуудын хамт үнэ төлбөргүйгээр хүргэхээс гадна уул уурхайн

салбарт өрнөж буй үйл ажиллагааны талаар дараах гол статистик тойм мэдээллүүдийг цахим хуудсаар (<http://eitimongolia.mn/>) олон нийт иргэдэд толилуулж байна.

ЗОРИЛГО

Уул уурхайн салбарт өрнөж буй үйл ажиллагааны талаарх гол мэдээллүүдийг интернетээр олон нийтэд хүртээмжтэй, нээлттэй болгох



ЗОРИУЛАЛТ

Газрын тос, байгалийн хий, ашигт малтмал зэрэг байгалийн баялгийг хэрхэн удирдаж буй талаар иргэд, олон нийтэд үнэн зөв мэдээлэх, мэдлэгийг нэмэгдүүлэх

Цахим тайлагналын системийг боловсруулахад баримталсан зарчим



Олон нийтэд мэдээллийг нээлттэй байлгах



Хэрэглэгч мэдээллийг бүх төрлөөр харах, татах, төрөл бүрийн байдлаар задлан шинжлэх боломжтой байх

Цахим хуудаснаас авах мэдээлэл

- Олгогдсон тусгай зөвшөөрлийн статистик мэдээлэл
- Эдийн засагт оруулсан хувь нэмрийн талаарх статистик мэдээлэл
- Байгаль орчны нөхөн сэргээлтийн статистик мэдээлэл
- Татвар төлбөрийн статистик мэдээлэл
- Бүтээгдэхүүн борлуулалтын статистик мэдээлэл
- Ашиг хүртэгч эздийн ил тод байдал
- Тусгай зөвшөөрлийн хөдөлгөөний статистик мэдээлэл
- Хандив дэмжлэгийн статистик мэдээлэл
- Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ
- Ил тод, нээлттэй компаниуд
- Хайгуулын ажлын статистик мэдээлэл
- Нутгийн захиргааны байгууллага, тусгай зөвшөөрөл эзэмшигч хооронд байгуулсан гэрээ

ОЛБОРЛОХ САЛБАРЫН ҮЗҮҮЛЖ БУЙ НИЙГМИЙН ДЭМЖЛЭГ

Нийгмийн хөрөнгө оруулалт, зарцуулалтад компаниудаас нийгмийн сайн сайханд зориулан гаргасан зардлууд багтдаг ба эдгээр

нь ихэвчлэн уул уурхайн ойр орчмын нутгийн иргэдэд зориулагддаг.



Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын нэгтгэлд хамрагдсан 230 компаниас 2017 онд мөнгөн ба мөнгөн бус хэлбэрийн хандив, дэмжлэгийг төрийн болон орон нутгийн байгууллагуудад үзүүлсэн. 2017 онд нэгтгэлд хамрагдсан компаниудаас 82

компани нийт 30,758 сая төгрөгийн мөнгөн ба мөнгөн бус хандивыг олгосон байна. Нийт хандив, дэмжлэгийн 89.5%-ийг Оюу Толгой ХХК, Өсөх зоос ХХК, Цайртминерал ХХК, МоЭнКо ХХК, Энержи Ресурс ХХК, Болд төмөр Ерөө гол ХХК гэсэн 6 компани үзүүлжээ.



Хандив, тусламжаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа (сая төгрөг)

Цэцэрлэг, сургууль	108.87
Орон нутгийн оюутны сургалтын төлбөр	79.55
Наадам тэмдэглэн өнгөрүүлэхэд	320.43
Ойн арга хэмжээнд	317.66
Цагаан сарын баярт	72.96
Спорт	69.00
Овоо тахилга	9.84
Эмнэлэг	57.00
Өмнөговь аймгийн Говийн Оюу Хөгжлийн Сан	23,991.39
Малчдад	95.47
Гал түймэрт	77.77
Ахмадуудад	12.74

Эх сурвалж: Олборлох үйлдвэрлэлийн компаниудаас ирүүлсэн мэдээлэл

Төрийн байгууллагууд болон компаниудаас ирүүлсэн мэдээллүүд нь зөрүүтэй байсан тул тохируулга хийж зөрүүг тохируулсан. Дээр дурдсанчлан заавал тайлагнах хандив

дэмжлэгүүдийг нэгтгэлд оруулж тохируулга хийсэн бол сайн дурын хандив, дэмжлэгүүд тохируулга хийгдээгүй болно.

НӨХӨН СЭРГЭЭЛТ

Уул уурхайн салбар байгаль орчинд хамгийн их доройтол учруулдаг, байгалийн нөхөн сэргээгдэхгүй баялгийг ашигладаг, Монголын ард түмний уламжлалт нүүдлийн мал аж ахуйд сөргөөр нөлөөлдөг.

Байгаль орчныг хамгаалах шаардлага хангуулах зорилгоор холбогдох сум, дүүргийн Засаг даргын зөвшөөрлөөр нээсэн тусгай дансанд тусгай зөвшөөрөл эзэмшигч уул уурхайн компаниуд нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд шаардагдсан тухайн жилийн төсвийн 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн дүнг шилжүүлэх үүрэгтэй.


НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Газрын хэвлийн тухай хууль (1988)
- Ашигт малтмалын тухай хууль (1997, 2006)
- Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль (2009)
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2001, 2006, 2012)



БОАЖЯ-ны мэдээлснээр 2017 онд нийт 1,326 сая төгрөгийн нөхөн сэргээлтийн зардал Байгаль хамгаалалтын тусгай дансанд төвлөрсөн ба буцаан олголт хийгдээгүй байна. 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн

эцсийн үлдэгдэл нь 12,626 сая төгрөг байна. Тухайлбал:




Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам

2017 оны уулын ажлын болон нөхөн сэргээлтийн гүйцэтгэлийн мэдээлэл

АМГТГ-ын ирүүлсэн мэдээгээр 2017 онд нийт 917.6 га талбай газар уулын ажилд хамрагдсанаас 61% буюу 556.0 га талбай газарт нөхөн сэргээлт хийгдэж 2,560.0 сая төгрөг зарцуулсан байна. Өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд уул уурхайн олборлолтын үйл ажиллагааны улмаас нийт 28,657 га талбай уулын ажилд хамрагдсан байна. Үүнээс техникийн нөхөн

сэргээлт хийсэн талбайн хэмжээ 12,891 га, биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайн хэмжээ 8,322 га, нөхөн сэргээлтэд зарцуулсан зардал 97 тэрбум төгрөг, байгаль орчинг хамгаалахад зарцуулсан зардал 67 тэрбум төгрөг байна. Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй компаниудын уулын ажлын болон нөхөн сэргээлтийн 2017 оны гүйцэтгэлийг харууллаа.




Эх сурвалж: Ашигт малтмал, газрын тосны газар, статистик-2017

АШИГЛАСАН УСНЫ МЭДЭЭЛЭЛ

Монголын ОУИТБС-ын ОТАХ-ийн гишүүдийн саналаар 2017 оны ОУИТБС-ын нэгтгэл тайланд сонгогдсон уул уурхайн компаниудын ашигласан усны хэмжээг ил тод болгохыг хүссэн. Иймд ашигласан усны мэдээллийг компаниудаас авах зорилгоор цахим тайлагналын системд шинэ маягт оруулахад

132 компани ашигласан усны мэдээллээ бидэнд ирүүлсэн.

Маягтыг бөглөсөн 132 компанийн мэдээллийг нэгтгэж үзэхэд нийт 73,696 мян.м³ ус ашиглахаар гэрээ хийж түүнээсээ 68,183 мян.м³ буюу гэрээлсэн усны 92.5%-ийг ашигласан байна.



Ашигласан усны хэмжээгээр Эрдэнэт, Оюу Толгой, Шивээ-Овоо, Эрдэнэс Таван толгой, Багануур компаниуд тэргүүлж байна. “Доншен газрын тос Монгол” ХХК 4,432 мян.м³ ус ашиглах гэрээ хийсэн боловч

165 мян.м³ ус ашигласан гэж тайлагнасан ба үүний шалтгааныг энэ жил шуурга, тоос багатай байсан тул тоосжилт дарах усыг хэмнэж ажилласан хэмээн тайлбарлажээ.

Хамгийн их ус ашигласан компаниудын мэдээллийг харуулав:

Компанийн нэр	Багануур	Эрдэнэс Таван толгой	Шивээ-Овоо	Эрдэнэт	Оюу Толгой
Гадаргын ус	68 МЯН.М ³	0 МЯН.М ³	0 МЯН.М ³	0 МЯН.М ³	0 МЯН.М ³
Гүний ус	5,634 МЯН.М ³	3,286 МЯН.М ³	3,496 МЯН.М ³	21,325 МЯН.М ³	16,488 МЯН.М ³
Саарал ус	1 МЯН.М ³	0 МЯН.М ³	0 МЯН.М ³	1,623 МЯН.М ³	458 МЯН.М ³

ХОГ ХАЯГДЛЫН МЭДЭЭЛЭЛ

Монголын ОУИТБС-ын ОТАХ-ийн гишүүдийн саналаар хог хаягдлын мэдээллийг цахим тайлангийн маягтаар нэгтгэсэн ба дэлгэрэнгүй байдлаар 113 компани мэдээллээ оруулсан.

2017 онд 113 компани нийт 318.5 сая төгрөгийг хог, хаягдлын төлбөрт төлсөн байна. Нийт төлбөрийн 69%-ийг Саусгоби Сэндс, Эрдэнэт компаниуд төлжээ.



Олборлох салбарын томоохон аж ахуйн нэгж болох Оюу Толгой компани улсад хог хаягдлын төлбөр төлдөггүй ба нийт 3.9 мян.м³ хог хаягдлыг дахин боловсруулж,

компани дотроо ашигласан гэж мэдээлсэн. 17 компани тогтмол дүнгээр хогны хэмжээнээс хамаарахгүйгээр төлбөр төлсөн байна.

Хамгийн их хог хаягдлын төлбөр төлсөн компаниудын хогны хэмжээ:

Компанийн нэр	Энгийн хог хаягдлын хэмжээ	Аюултай хог хаягдлын хэмжээ	Дахин боловсруулсан аюултай хог хаягдлын хэмжээ	Төлсөн төлбөр	Нийт хогны төлбөрт эзлэх хувь
Бадрах Энержи	0.6 МЯН.М³			9.2 сая.төг	3%
АУМ АЛТ	0.05 МЯН.М³			10.0 сая.төг	3%
Монголын Алт МАК	1.36 МЯН.М³			10.9 сая.төг	3%
Саусгоби Сэндс	0.2 МЯН.М³	0.1 МЯН.М³	0.1 МЯН.М³	108.7 сая.төг	34%
Эрдэнэт	17.9 МЯН.М³			112.1 сая.төг	35%

БҮЛЭГ 6. ЗӨВЛӨМЖ

2016 ОНЫ ТАЙЛАНД ӨГСӨН ЗӨВЛӨМЖ, ТҮҮНИЙ БИЕЛЭЛТ:

01

Хэрэгжүүлсэн:

- Төрийн байгууллагуудад ОУИТБС-ийн ач холбогдлыг таниулах
- НӨАТ-ын төлөлтийг ангилж тайлагнах

02

МОУИТБС-ын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд оруулсан:

- ТӨААН-үүдийн чадавхийг бэхжүүлэх

03

Хараахан хэрэгжүүлээгүй, цаашид арга хэмжээ авах шаардлагатай:

- Төрийн байгууллагуудаас тайлагнасан ОУИТБС-ын мэдээллийг ЯАГ баталгаажуулдаг байх
- МОУИТБС-ийн зүгээс үндсэн үйл ажиллагаа нь олборлох үйлдвэрлэлийн бус компаниудыг ялгаж таних, тайлагнах тогтолцоо бий болгох
- АМГТГ-аас БХГ-г ил тод болгох
- АМГТГ-аас Тусгай зөвшөөрлийн ил тод байдлыг сайжруулах

2017 ОНЫ ТАЙЛАНД ӨГСӨН ЗӨВЛӨМЖҮҮД:



ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ САЙЖРУУЛАХ

- Ил тод байдлын тухай хууль батлуулах,
- ОУИТБС-ийн системд ирүүлсэн тайлан мэдээг баталгаажуулах журмын нийцлийг сайжруулах



ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОО, ХАРИУЦЛАГЫГ САЙЖРУУЛАХ

- Ашигт малтмал, газрын тосны салбарын компаниудын санхүүгийн мэдээллийн ил тод байдлыг хангахад төр хэрхэн оролцох тухай бодлого боловсруулж, хэрэгжүүлэх
- Тусгай зөвшөөрлийн ил тод байдлыг сайжруулах
- ОУИТБС-ын Стандартын Шаардлага 4.2-ын дагуу нийт үйлдвэрлэлээс Засгийн газарт ногдох хэмжээг мэдээлэх
- Үндэсний зөвлөл холбогдох төрийн яам, агентлагуудыг татан оролцуулж БХГ-нүүдийг ил тод болгох ажлыг зохион байгуулах
- ТӨААН-үүдийн аудитын дүгнэлтэд дурдсан зөрчилтэй асуудлуудыг засаж сайжруулах
- Гаалийн ерөнхий газартай жил бүр үүсдэг зөрүүгийн шалтгааныг тодруулах, шийдвэрлэх



ОРЛОГЫН БУС МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ

- МОУИТБС-аас төрийн байгууллагуудтай хамтрах
- Бенефициар өмчлөгчийн мэдээллийг цуглуулсан туршлага, сургамжийг 2019 онд үйл ажиллагаандаа тусгах
- Бенефициар өмчлөгчийн талаарх ойлголт болон нийцлийн асуудлыг сайжруулах



ЦАХИМ ТАЙЛАГНАЛЫГ САЙЖРУУЛАХ

- Төрийн байгууллага, ТӨААН, компаниудын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, бусад урсгалын мэдээллийг тусгай зөвшөөрөл бүрээр авах маягыг цахимжуулах
- Олборлох салбарын бүх ТӨААН-ийн аудитлагдсан иж бүрэн санхүүгийн тайланг дараах вэб хуудсуудаар олон нийтэд мэдээлэх

- ЯАГ-ын вэб хуудас www.audit.mn

- ОУИТБС-ын вэб хуудас www.eitimongolia.mn

- ТӨААН-ийн вэб хуудас

- Яамдын вэб хуудас

Монгол Улсын ОУИТБС-ын Ажлын албаны санаачлагаар, Харт Нойрс, “Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн санхүүжилт, дэмжлэгээр “Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын хураангуй тайлан-2017” товхимлыг Монгол Улсын ОУИТБС-ын 2017 оны нэгтгэлийн мэдээллийг иргэдэд хүргэх зорилгоор монгол хэлээр бэлтгэн гаргав.

Товхимлыг олон нийтийн хүртээл болгох нь бидний зорилго тул бүрэн болон хэсэгчлэн арилжааны бус зорилгоор ашиглаж болно. Ийнхүү ашигласан тохиолдолд эх сурвалжийг “Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын хураангуй тайлан-2017”, Монгол Улсын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Ажлын алба гэж тодотгоно уу.

Санал хүсэлт болон мэдээлэлтэй холбоотой лавлах зүйл байвал Ажлын албаны eti.secretariat.mn@gmail.com цахим шууданд ирүүлнэ үү.

ТОВХИМЛЫГ БОЛОВСРУУЛЖ, ХЯНАН ТОХИОЛДУУЛСАН:

Ерөнхий редактор:	Б.Осоргарав	“Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн Ерөнхий захирал, Удирдах партнер
Зөвлөх:	Дэвид Куйн	Их Британи улсын Харт Нойрс компанийн ахлах зөвлөх
Хянан тохиолдуулсан:	Ш.Цолмон	МОУИТБС-ын Ажлын албаны Зохицуулагч
	Б.Дэлгэрмаа	МОУИТБС-ын Ажлын албаны Харилцааны менежер
Боловсруулсан:	О.Идшинринжин	“Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн Дэд захирал, Партнер
	Н.Эрдэнэцог	“Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн Чанарын хяналтын хорооны дарга, Партнер
Техникийн туслах:	Т.Отгоннаран	“Улаанбаатар аудит корпораци” ХХК-ийн Бүртгэл санхүүгийн мэргэжилтэн

“Шинжилгээ, загварчлал, шийдэл” төрийн бус байгууллага нь инфографик, график дизайн, хэвлэлийн эх бэлтгэв.

Агуулгын боловсруулалт, дизайн зохиомж:	Ц.Ганчимэг, С.Мөнх-Алдармаа
График дизайнер, хэвлэлийн эх бэлтгэсэн:	Б.Алтансүх, А.Баатар, С.Бурмаа, Н.Отгон-Эрдэнэ

